

‘Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дүгээр хавсралт

УВС АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар /	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
Зорилт 1. Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал, төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна							
1.1	“Алсын хараа 2050” 1.1.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 13 дугаар зарлиг, АЗДҮАХ 2.2.8 Баруун монгол түмний “Баатарлаг тууль” хайлах арга хэмжээг зохион байгуулах	Орон нутгийн төсөв 15,0	Үйл ажиллагааны тоо Хамрагдагсдын тоо	Тууль хайлж, 7-8 минутын баримтат кино, лекц ЕБС-ийн 700 гаруй хүүхэд хамрагдсан.	Үйл ажиллагааны тоо 3 Хамрагдагсдын тоо 1200	Үйл ажиллагааны тоо: 4 Хамрагдагсад: 1300 Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Баатарлаг тууль хайлах” арга хэмжээг 2024 оны 02-р сарын 04-ны өдрүүдэд Улаангом хотноо ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа, монгол гэрт “Жангар тууль” хайлуулж бүртгэн баримтжуулалт хийх, Ойрад Монголын баатарлаг туулийн уламжлал ба хөгжлийн чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэг, ЕБС-ийн хүүхдүүд туулийн талаарх лекц зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж 1300 хүнийг хамруулсан.	100% 100%
1.2	Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.5, АЗДҮАХ 2.2.1, 2.2.5, 2.2.9. Икэлийн чуулгын урын санг нэмэгдүүлэх, гадаад, дотоодод	Орон нутгийн төсөв 5,0	Урын сангийн баяжилтын тоо Зохион байгуулсан	Урын санг 38 бүтээлээр баяжуулсан. Гадаад	Баруун бүсийн 4 аймаг, Увс аймгийн 15 суманд Икэлийн	Ойрад ХЖТ “Тэнгэрийн сэнтий” дуулалт бүжгэн жүжигт зориулан, хөгжмийн зохиолч Б.Эрдэнэбат хөгжмийн бүтээл туурвиж, икэлийн чуулгын урын санг 20-оор нэмэгдүүлсэн.	100% 90% (Бодит үнэлгээ 70%)

	сурталчлах, түгээн дэлгэрүүлэх		тоглолтын тоо Хамрагсдын тоо	дотоодын 8 удаагийн тоглолтод 4480 хүн хамрагдсан.	чуулгын тоглолт зохион байгуулж, 5000 хүн хамруулна. Урын санг 2-оор нэмэгдүүлнэ.	Баян-Өлгий аймаг болсон Монголын урлагийн ажилтны холбоо, ССАЖЗЯ-аас зохион байгуулсан Баруун бүсийн театрууд дунд “Дөрвөн цагийн нүүдэл” шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах бүсчилсэн уралдаанд Икэлийн чуулга бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, нэгдүгээр байранд шалгарсан бөгөөд Улаанбаатар хотод болох 2-р шатны шалгаруулалтад оролцохоор бэлтгэлээ хангаж ажиллаж байна. Мөн Улаанбаатар хот, Өмнөговь, Тариалан суманд шинэ бүтээлээ толилуулж 5000 гаруй хүнд хүргэсэн байна..	
1.3	Увс аймгийн ИТХ-ийн 2023 оны 16/03 тогтоолын хавсралт, АЗДҮАХ 2.2.1, 2.2.5, 2.2.9 1000 ихэлч бэлдэх	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний биелэлт	-	100%	Аймгийн хэмжээнд судалгаанд бүртгэгдсэн 126 икэлч байна. Ойрад ХЖТ, 12 сумын Соёлын төв болон Насан туршийн суралцахуйн төвөөр 547 хүн суралцаж байгаа бөгөөд нийт 673 икэлч бэлтгэгдсэн.	70% 70%
1.4	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 41.1, Засгийн газрын 2019 оны 369 дүгээр тогтоол, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 3.4 Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээний хүрээнд "Дээлтэй Монгол наадам", "Монголын сайхан орон" дүрслэх урлагийн үзэсгэлэн, "Монгол бахархал" гэрэл зургийн үзэсгэлэн	Орон нутгийн төсөв 15,0	Арга хэмжээний тоо	-	3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Үндэсний их баяр наадмын нээлт хаалтын үйл ажиллагааг ЗДТГ, СУАЖГ, Ойрад ХЖТ хамтран зохион байгуулсан. Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас 1. “Дээлтэй монгол-2024” наадам арга хэмжээний хүрээнд: - Сайхан дээлтэй хос, - Сайхан монгол дээлтэй хүүхэд, - Сайхан дээлтэй үзэгч, -Шилдэг үндэсний дээл урлаач	100% 100%

	арга хэмжээг зохион байгуулах					шалгаруулан шагнаж урамшуулсан -Шагай шүүрэх зэрэг тэмцээн 2. “Монгол бахархал” соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэнг баяр наадмын талбайд гаргах зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. 3. Музейгээс сан хөмрөгт хадгалагдаж буй 12 шилдэг уран зургаар “Монголын сайхан орон” үзэсгэлэн дэглэж 6000 гаруй үзэгчдэд үзүүлэн соёлын үйлчилгээг хүргэн ажилласан. 4. Ойрад ХЖТ-ын уран бүтээлчид “Тэнгэрийн сэнтий” дуулалт бүжгэн жүжгийн тоглолтыг 2 удаа тоглосон.	
1.5	Увс аймгийн ИТХ-ийн 2023 оны 16/03 тогтоолын хавсралт, АЗДҮАХ 2.5.3 Аймгийн Засаг даргын нэрэмжит “Авьяас 2024” хүүхдийн урлагийн наадам зохион байгуулах	Орон нутгийн төсөв 10,0	Хамрагдсан хүүхдийн тоо	2000	2100	“Авьяас 2024” наадмыг 2 үе шаттайтайгаар ЕБС, СӨБ-ын 4 насны ангилалаар , 48 төрөлд 2492 хүүхэд хамруулан зохион байгуулж, 199 хүүхдийг шагнаж урамшуулсан. Мөн авьяасыг хөгжүүлэхэд амжилт үзүүлсэн 5 багшийг аймгийн Засаг даргын “Жуух” бичиг, мөнгөн шагналаар шагнасан.	100% 100%
Зорилт 2. Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх							
1.6	Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.3, АЗДҮАХ 2.2.1, 2.2.5, 2.2.9. Язгуур өв соёлоо гадаад, дотоодод сурталчлан дэлгэрүүлэх, соёлын аялал жуулчлалыг өргөжүүлэх	Улсын төсөв 30,0 сая Орон нутгийн төсөв 20,0	Арга хэмжээний тоо	3	3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулна	Нийт 5 арга хэмжээнд 9546 хүнд хүргэж, үйлчилсэн байна. 1.“Гэр үзэсгэлэн”-ийн арга хэмжээ 2024 оны 05-р сарын 04-12-ыг хүртэл Улаанбаатар хотод Чингисийн талбай дээр зохион байгуулагдсан. Увс аймгаас Баяд /Баяд өргөө/ гэрээр оролцож, Баяд угсаатны бүлгийн өв соёл, гэр, эд өлгийн зүйлс, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, 3 боловсролын хөтөлбөр /1106/ хэрэгжүүлж, нийт 6274 хүнд үйлчилсэн. 2.Завхан суманд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Тэмээний баярыг “Тэмээ-Мөс-	100% 100%

						Загасчлал” нэртэйгээр зохион байгуулж, 670 хүн үзэж сонирхсон. 3. “ОЙРАД ТҮМЭН-2024” олон улсын язгуур урлагийн наадамд Халимаг, Тува, Шинжааны БНАУ, Увс аймгийн 19 сумдын өв тээгчдийн төлөөлөл 40 уран бүтээлч уртын дуу, бий биелгээ, хөөмий, цуур, ерөөл магтаал, тууль, икэл, морин хуур төрлөөр оролцож, шалгарсан 16 уран бүтээлчийг Ойрад түмэн медаль, Алтан гэрэгэ, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулсан. 4. Аймгийн Музей ОХУ-ын Красноярскийн хязгаар нутаг Шушинский районд “Монголчуудын өв соёл” гэрэл зургийн түр үзэсгэлэн гаргаж видео, гэрэл зургаар соёл, ёс заншил, монгол гэрийн үүсэл хөгжил, гэр бүрэх үйл ажиллагаа зэргийг таниулан сурталчлах түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулсан. 5. Бөхмөрөн сум язгуур өв соёлоо сурталчлах зорилгоор Баянөлгий аймгийн Ногоон нуур сумын соёлын төвтэй хамтран “Наурыз-2024” уран бүтээлийн тоглолтыг казакын ард иргэдэд хүргэсэн.	
1.7	Увс аймгийн ИТХ-ийн 2023 оны 16/03 тогтоолын хавсралт, АЗДҮАХ 2.2.1 Сумдын соёлын төвүүдийг түшиглэн ардын авьяастан, өв тээгчдийг сурталчлах, шавь сургалт, соёлын бусад арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Өв тээгчдийн тоо	508	518	11 суманд 61 өв тээгч, Ойрад театр 2 өв тээгч шинээр бүртгэгдэж нэмэгдэж, СББӨ-ийн Улсын нэгдсэн санд бүртгэгдсэн өвлөн уламжлагч 550 болж өссөн. 14 соёлын төвд шавь сургалтад 603, Ойрад ХЖТ-ын шавь сургалтад 577 хүүхэд, нийт 1180 хүүхэд шавь сургалтад хамрагдсан байна. - Музейгээс Өлгий, Өмнөговь сумын орон нутаг судлах танхимын үзүүллэг дэглэлт, хаяг тайлбар, хадгалалт хамгаалалт, үзмэр эд өлгийн зүйлсийг ерөнхий дэвтэрт бичилт хийх, үнэлгээ тогтоох, эрдэм шинжилгээний тодорхойлолт бичих талаар мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.	100% 100%

1.8	Соёлын тухай хуулийн 21.1.1, Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоол, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 4.5 “Нүүдэлчин Монгол” олон улсын фестиваль зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, оролцох	Улс, орон нутгийн төсөв 15,0	Оролцсон байдал, оролцогчдын тоо	42 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, отог дээрээ 5000 гаруй хүн хүлээн авч үйлчилсэн.	Батлагдсан удирдамжийн дагуу уран бүтээлч авьяастнуудыг бэлтгэн, оролцоог ханган оролцсон байна.	“Нүүдэлчин Монгол” Дэлхийн соёлын олон улсын фестивалд Увс аймгаас нийт 40 хүний бүрэлдэхүүнтэйгээр 6600 гаруй хүнд хүрч үйлчилсэн. “Нүүдэлчин Монгол” наадамд Увс нутгийн чацарганы шүүс, тавгийн идээгээр дайлуулан, тарианы соёл, цагаан идээ, айраг, архи нэрэх соёл, монгол гутал оёх, араг хийх технологи, монгол үндэсний дээлний соёлтой танилцаж, бий биелгээ, уртын дуу, тууль хайлах, алтайн бүүвэй хайлах зэргийг багтаасан язгуур урлагийн тоглолтыг отог дээр хуваарийн дагуу 3 өдрийн турш нийт 15 удаа, их тайзан дээр 1 удаа тус тус зохион байгуулсан. Мөн 4 уран бүтээлчийн уран бүтээлээр гар урлалын үзэсгэлэн гаргасан	100% 100%
1.9	Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.1 Соёлын сэргэлт-2024 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцох	Улсын төсөв 3,0	Арга хэмжээний тоо Хамрагдсан хүний тоо	Арга хэмжээ-143, хамрагдсан хүн-28755	Батлагдсан удирдамжийн дагуу уран бүтээлч авьяастнуудыг бэлтгэж оролцоог ханган оролцсон байна.	Соёлын сэргэлт-2024 аяны хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу 2024 оны 05-р сарын 04-12 хүртэл Улаанбаатар хот, Чингисийн талбайд “Гэр үзэсгэлэн”-ийн арга хэмжээ зохион байгуулагдаж, аймгаа төлөөлөн Баяд угсаатны бүлгийн гэрээр оролцож, 6274 хүнд үйлчилсэн. Мөн 2024 оны 05-р сарын 06, 07-нд зохион байгуулагдсан Удирдах ажилтын зөвлөгөөн, Морин хуурын үндэсний чуулганд соёл урлагийн салбарын 24 удирдах ажилтан оролцсон.	100% 100%

Зорилт 3. Соёл, урлагийн байгууллагын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоог бий болгож, тэднийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.10	Соёлын тухай хуулийн 24.1.2, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 1.1 Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар дэмжлэг үзүүлэх	Улс болон орон нутгийн төсөв	Хөнгөлттэй нөхцөлөөр сургасан, нийгмийн баталгаа дэмжлэг үзүүлсэн ажилтны тоо	125 ажилтанд 573.5 сая төгрөгийн тэтгэмж олгосон. 7 ажилтанд 820.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн	Мэргэжлийн ажилтны хангалтыг 79 хувь буюу 1%-иар нэмэгдүүлнэ . 14 ажилтанд 98.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.	Нийт 12 сургалтад, 166 хүн хамрагдсан байна. Мэргэжлийн боловсон хүчний хангалт 79,5 хувь байна Үүнд: 1. Соёлын төв, ордны гэрэл, дууны техник, тайзны тоног төхөөрөмжийн ажиллагааг хариуцан ажилладаг ажилтнуудыг мэргэшүүлэх богино хугацааны сертификат олгох сургалтад 6 хөгжмийн багш 2. “Тонж манлай-21” төслийн хүрээнд үндэсний бөхийн засуул, морь, бөх цоллооч бэлтгэх 5 хоногийн танхимын сургалт зохион байгуулагдаж, 15 сумын 60 гаруй өв тээгч 3. “Дэвжих хяргас” ТТБ-тай хамтран Нийтийн цэнгээнт бүжгийн мэргэжлийн сертификат олгох сургалтыг зохион байгуулж, соёлын төвийн 11 бүжгийн багш 4. Чингис хаан музейгээс зохион байгуулсан "Орчин цагийн музей-100 жил" эрдэм шинжилгээний хуралд музейн 8 албан хаагч 5. БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгт болсон “Museum summit-2024 ” олон улсын чуулга сургалтад музейн захирал 6. Байгалийн түүхийн музейн гэрэл зургийн үзэсгэлэн, Чойжин ламын сүм музей дээр зохион байгуулагдсан боловсролын хөтөлбөр үйл ажиллагаанд 8 ажилтан албан хаагч 7. "Үзмэрийн хаяг тайлбарыг QR кодоор уншуулах" нь, "Соёлын биет бус өвийг музейд хадгалаж хамгаалах" нь сэдэвт сургалтад 6 ажилтан албан хаагч 8. “Баруун бүсийн музейн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх нь”	100% 100%
------	--	------------------------------	---	--	--	---	-------------------------

						сэдэвт сертификаттай сургалтад 5 ажилтан 9. “МОНГОЛЫН МУЗЕЙ-100”жил нэгдсэн чуулганд 6 ажилтан албан 10. СУИС, УДЭТ-аас сургагч багш нарыг урьж, 7 хоногийн хугацаатай 2 кредит цагийн сертификат олгох академик сургалт зохион байгуулж, 54 уран бүтээлч тус тус хамрагдсан. 11. Баруунтуруун, Өлгий, Цагаанхайрхан, Ховд сумаас Соёлын төвийн 4 ажилтанг СУИС-ын харъяа Соёлын дээд сургуульд 12. Монгол Улсын соёлын биет бус өвийг хамгаалахчадавхийг бэхжүүлэх үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад 1 албан хаагч Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан соёл урлагийн салбарын ажилтанд олгох 5 жил тутамд олгох тэтгэмжийг 10 байгууллагын 16 ажилтанд 114,7 сая төгрөгний тэтгэмж олгосон.	
1.11	Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Шинэ сэргэлтийн бодлого 4.2, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 1.2 Соёл, урлагийн байгууллагуудад шилжин суурьшин ажиллах иргэдийг бодлогоор дэмжих	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	2023 онд 5 албан хаагчийг шилжин ажиллах амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж хөнгөлөлт дэмжлэг үзүүлсэн	Орон нутгийн соёлын байгууллага д хотоос шилжин суурьшиж ажиллах 1-ээс доошгүй албан хаагчид дэмжлэг үзүүлнэ.	Улаанбаатар хотоос шилжин сууршиж Зүүнхангай сумын Соёлын төвийн даргын албан тушаалд тусгай шалгалт өгч, томилогдон ажиллаж байгаа ажилтныг Сумын ЗДТГ-аас бодлогоор дэмжин ажиллаж байна. Наранбулаг сумын соёлын төв хөгжмийн багшийн дутагдалтай бөгөөд шаардлагатай боловсон хүчнийг хөгжмийн багшаар гаднаас авч ажиллуулж мэргэжлийн сургуульд хамруулан мэргэшүүлэх чиглэлээр ажиллаж байна.	100% 100%

1.12	Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.7 Соёл, урлагийн байгууллагын орчин үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагын стандартыг хангахад дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ 1	2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн байна.	Нийт 7 сумын соёлын төв 104.6 сая төгрөгийн техник хэрэгслээр хангагдсан. 1. Зүүнхангай, Тариалан, Өндөрхангай сумын соёлын төвийн барилгын их засвар, Музейн барилгын их засварын ажлуудыг 100%-ийн гүйцэтгэлтэйгээр хийж хүлээлгэн өгсөн. Баруунтурууны соёлын төвийн засварын ажил 80%-тай явагдаж байна. 2. Аймгийн Музей HITACHI-CV-940WR 15л багтаамжтай 1ш, хагас автомат угаалгын машин 1ш, GPS багаж 1ш тоног төхөөрөмжөөр хангагдлаа. 3. Бөхмөрөн -хяналтын системийн техникийн шаардлага хангасан 2 ш камер дэлгэцийн хамт, ОНХ сангаас 19 сая, хандив тусламжаар 9,8 сая нийт 28,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж,хувцас хэрэглэл шийдвэрлэлээ. 4. Зүүнговь - Музей 10,8 сая төгрөгөөр тохижилтын ажил хийгдсэн ба байгууллагын дотоод нөөц боломжинд тулгуурлан хөгжим техник, гэрэл гэрэлтүүлэг, хувцас хэрэглэлээр хангасан. 5. Наранбулаг - Соёлын төвийн их засварын ажлын санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангаас 232,7 сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлүүлсэн ба их засварын ажил 12 сарын 20-ны өдөр хүлээлгэн өгөх ажлын хувиартайгаар ажиллаж байна. 5-н Угсаатны бүрэн дээл хувцас, үндэсний болон орчин үеийн ком хөгжим техникийг авах санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангаас 25,0	100% 100%
------	--	--------------------	--------------------	--------------------------------	--	--	----------------------

						сая хөгжим парк шинэчлэл, 10,0 сая ₮ хувцас хэрэглэлийг шийдвэрлэлээ.	
Зорилт 4. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.							
1.13	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4, Засгийн газрын 2022 оны 314 - р тогтоол, 2023 оны 481 дүгээр тогтоол, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 5.1 Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах	Улс орон нутгийн төсөв	Баримт бичиг батлагдсан байна.	-	Батлагдсан төлөвлөгөө-1 Хэрэгжилтийн тайланг Соёлын яаманд хүргүүлсэн байна.	1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 чиглэл, 90 салбарт хамаарагдах соёлын бүтээлч үйлдвэрлэгч иргэн, ААН-ийн судалгааг авч байна. Тайлбар: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль 2024 оны 05-р сарын 16-ны өдөр батлагдсан. Мөн Соёл бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, стратегийг Соёлын сэргэлт аяныг баруун 5 аймагт бүсчилж хийх үеэр тодорхойлж өгөх талаар Соёлын яамнаас чиглэл өгсөн боловч аяныг бүсчилж зохион байгуулаагүй. Иймд 4 жилийн хугацаанд хэрэгжих Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөөг Соёлын бүтээлч үйлдвэрлэл III хөтөлбөр, 2024 оны сонгуулийн үр дүнгээр сонгогдсон Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулан боловсруулж батлуулахаар төлөвлөн ажиллаж байна. 2. “Соёлын бүтээлч сар-2024” аяны хүрээнд соёл, урлагийн 23 байгууллагаар 496 арга хэмжээ зохион байгуулагдаж, 34264 хүн хамрагдсан байна. Үүнд: - Хүүхэд 18145 - Хөгжлийн бэхшээлтэй үйлчлүүлэгч 319 Соёлын бүтээлч сар-2024 аяны статистик мэдээ - Музейн үзэгчийн тоо - 4470, - Урлагийн тоглолт үзэгчийн тоо -10287,	100% 90% Судал гааг тодруулах

						- Номын сангийн уншигчийн тоо- 3638, - Боловсролын хөтөлбөрт оролцогчдын тоо-5887, - Хэлэлцүүлэг хуралд оролцогчдын тоо-2345, Нөлөөллийн ажилд оролцогчдын тоо 7215, - Цахим орчинд сурталчилсан контентын хандалтын тоо-139277 - 86 үзэсгэлэнд 4470 хүн тус тус хамрагдлаа.	
1.14	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 5.2 Хувийн хөрөнгө оруулалтаар соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, урамшуулах	Орон нутгийн төсөв	Иргэн, хуулийн этгээдийн тоо	5 арга хэмжээг зохион байгуулсан.	5-аас доошгүй иргэн, хуулийн этгээдийг дэмжсэн байна	Хуулийн этгээд 3, Иргэн 8 1. “Гэр үзэсгэлэн”-ийн арга хэмжээний хүрээнд 8 ханатай гэр хийх Ойрад хийц ХХК-тай 50,8 сая төгрөгийн гэрээ, 1 иргэнд 1,5 сая төгрөгөөр оньсон авдар хийх гэрээг тус тус байгуулж, Улаанбаатар хотноо үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд оролцуулж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээлийн үзэсгэлэн худалдаа явуулах боломжийг олгож, 20 гаруй сая төгрөгний борлуулалт хийсэн. 2. Зүүнговь сумын хэмжээнд бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээлийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шилдэг 5 бүтээлийн эзнийг соёлын төвийн зүгээс шагнаж урамшуулсан. 3. Ховд сумын Соёлын төвөөс икэл хуур урлаач 1 иргэнтэй 10ш икэл хуур засварлуулахаар гэрээ байгуулан дэмжиж ажилласан. 4. Соёл, урлагийн газар, Дэвжих-Хяргас ХХК-ийн Хийморь төв дэх Виктория бүжгийн клубтай хамтран Улаанбаатар хотоос мэргэжлийн багш нарыг урьж, 2024 оны 09 дүгээр сарын 14, 15, 16-ны өдрүүдэд “Цэнгээнт бүжгийн ахисан шатны сертификат олгох сургалт”-ыг зохион байгуулж, 15 сумын Соёлын төвийн бүжгийн багш нарыг хамрууллаа. Мөн Биеийн тамир спортын газар, Улаангом сумын Соёлын төвийн хамтран 2024 оны 09-р сарын 25-ны	100% 100%

						өдөр “Нийтийн цэнгээнт бүжгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн” зохион байгуулсан. Тус тэмцээнд сургалтад хамрагдсан багш нараар шавь бэлдүүлж, 5 төрөлд 35 оролцогч оролцсон. 5. Увс аймгийн Улаангом сумын Соёлын төвд бүжгийн урлагийг сурталчилсан Ховд аймгийн “Алтан замын жигүүр” бүжгийн клуб хамт олонд Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын зүгээс талархал гардуулж урамшуулсан. 6. Ойрад угсаатны хувцас урлаач 1 иргэнийг аймгийн наадмаар шилдэг бүтээлч үйлдвэрлэгчээр шалгаруулж шагнаж урамшуулсан.	
1.15	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 5.3 Соёл, урлагийн байгууллага, концертын танхим, караоке, бар, ресторанд оюуны өмч, зохиогчийн эрхийн талаарх тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо	Дүгнэлт-1 Сургалт-1	Дүгнэлт 1 2-оос доошгүй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	- Соёл, урлагийн 17 байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, зөвлөн туслах ажлын хүрээнд оюун өмч, зохиогчийн эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. - Оюуны өмч зохиогчийн эрхийн талаарх цахим сургалтад харъяа 22 байгууллагын удирдлагуудыг хамруулсан. - Улсын байцаагчийн тайлан нэмэх	100%
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
Зорилт 1. Бүх нийтийн соёлын боловсролын арга хэмжээг боловсруулан соён гэгээрүүлэх ажлыг идэвхжүүлж, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.							
2.1	Соёлын тухай хуулийн 24 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо, нөлөөллийн	Үйл ажиллагааны тоо 10	Байгууллага тус бүр төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэ	Бүх нийтийн соёлын боловсролын ерөнхий төлөвлөгөөг СУГ, салбар 22 байгууллага боловсруулан батлуулж, нийт 236 арга хэмжээ	100% 100%

	хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.2 Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний төлөвлөгөө, “Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх нөлөөллийн цогц ажлуудыг зохион байгуулах” тухай сайд нарын хамтарсан албан даалгаврын хэрэгжилтийг хангах		аяны тоо		н байна. 20-оос доошгүй арга хэмжээ, 2-оос доошгүй нөлөөллийн аян зохион байгуулсан байна.	зохион байгуулж, 45145 хүн хамрагдсан. “Уншигч Увсчууд”, “Соёл, урлагаар хүмүүжье”, “Бид хүүхдийн төлөө” зэрэг нөлөөллийн аяны хүрээнд нийт 113 арга хэмжээ зохион байгуулагдаж, 42661 хүн хамрагдсан. 1. “Уншигч Увсчууд” нийтийн ном уншлагын нөлөөллийн аянд 6 арга хэмжээ зохион байгуулагдаж, 17361 2. “Соёл, урлагаар хүмүүжье” нөлөөллийн аяны хүрээнд 65 арга хэмжээ зохион байгуулагдаж 12300 3. “Бид хүүхдийн төлөө” нөлөөллийн аяны хүрээнд 42 арга хэмжээ зохион байгуулагдаж 13000 хүн тус тус хамрагдсан.	
2.2	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.17, Номын сангийн тухай хуулийн 23.2, 24.4, БСШУСайдын 2018 оны А/683 дугаар тушаал, МУ-ын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.6 "Номын баярын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, номоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Арга хэмжээний тоо Хамрагдсан хүний тоо	Зохион байгуулсан арга хэмжээ 20 Хамрагдсан хүний тоо 5500	20-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 6000 хүн хамруулна.	“Үндэсний бичиг соёлын өдөр, Номын баяр-2024” арга хэмжээг хавар, намар 2 удаа нийтийн номын сан, 19 сумдын номын сангаар нийт 270 арга хэмжээ зохион байгуулагдаж, 19309 хүн хамрагдсан. “Уншигч Увсчууд” нийтийн ном уншлагын нөлөөллийн аяны хүрээнд: - Байгууллага хоорондын уншлага-2723, - Номтой нөхөрлөө хүүхдэд зориулсан арга хэмжээ-2031 - Алслагдсан багуудад явуулын номын сангийн үйлчилгээ-3335 - Зохиолч уншигчдын уулзалт-1820 - Номтой өглөө арга хэмжээ-2031 - Гэр бүлийн уншлага-417 зэрэг арга хэмжээ зохион байгуулагдаж, нийт 17361 хүн хамрагдсан.	100% 100%

2.3	Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн зусланд нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах үйл ажиллагаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо	Арга хэмжээ-2	2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн байна.	1. Завхан аймагт болсон хүүхдийн зуслангийн хөтөлбөрт сум тус бүрээс 3 хүүхэд, нийт 57 хүүхэд зусланд хамрагдаж, нүүдлийн ахуй соёлтой танилцсан. 2. Бөхмөрөн сумын Соёлын төв "Гэр зуслан" ажиллуулсан. 3. Нийтийн номын сан иргэд,хүүхэд багачуудын зуны амралтыг үр өгөөжтэй өнгөрүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилгоор 2024-06-25-ны өдрөөс 2024-07-25-ны өдөр хооронд Гашууны голд "Гэр номын сан" ажиллуулсан.	100% 100%
2.4	Соёлын тухай хуулийн 4.1.2, 14.2.1, Монгол хэлний тухай хуулийн 7.2, 14.1.1, 17 дугаар зүйл, "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III" 3.2.15, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.8 "Үндэсний бичиг, соёлын жил-2024, "Эх хэлний өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлж, "Хос бичигтэн" аймаг уриалгыг гаргаж, Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Үндэсний бичиг үсгийн баяр-2023, Эх хэлний өдөр-2023, "Хос бичигтэн байгуулл ага" арга хэмжээг хэрэгжүүлсэн.	10-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	"Үндэсний бичиг соёлын өдөр-2024"-ийн хүрээнд монгол хэл, бичгийн 52 арга хэмжээ зохион байгуулагдаж, 6000 гаруй хүнийг хамруулсан. Соёл урлагийн салбарын 22 байгууллагаас16 байгууллага гадна хаягаа монгол бичгээр хаягжуулж, соёл, урлагийн 230 гаруй албан хаагч монгол бичгийн сургалтад тогтмол хамрагдаж, 32 ажилтан монгол бичгээр компьютерт бичих аргазүйн сургалтад хамрагдсан.	100% 100%

2.5	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 1.6, Увс аймгийн ИТХ-ийн 2023 оны 16/03 тогтоолын хавсралт, АЗДҮАХ 2.2.0 Сумдын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах соёлын олон талт арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо	4	6-аас доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн байна.	Өндөрхангай, Зүүнхангай, Өмнөговь, Тэс, Бөхмөрөн, Ховд сумын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд Ойрад хөгжимт жүжгийн театраас урлагийн тоглолт зохион байгуулан, дэмжлэг үзүүлэн ажилласан. Тэс сумын 100 жилийн ойгоор Увс аймгийн Музейн үзмэр болох Баяд угсаатны эд өлгийн зүйлийн 33 гэрэл зургаар үзэсгэлэн гаргасан. Мөн Соёлын яамнаас Өндөрхангай соёлын төвд 23 нэр төрлийн компьютер, техник, дуу шуумны тоног төхөөрөмж, Зүүнхангай соёлын төвд компьютер, номын сангийн тавилага болон 240 үзэгчийн сандал, Өмнөговь, Ховд, Тэс, Бөхмөрөн соёлын төвд компьютер, техник хэрэгсэл, морин хуур, даралтат хөгжим зэрэг тавилага тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.	100% 100%
2.6	Соёлын тухай хуулийн 9.1.4, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын Зорилт 1.4. Эрдэм судлал, түүх, соёл судлалын ажлыг зохион байгуулах, дэмжих	Орон нутгийн төсөв 30.0	Арга хэмжээний тоо	2	3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Арга хэмжээний тоо 4 1.Төр нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, Маршал Ю.Цэдэнбалын холбогдолтой 80 гаруй үзмэр эд өлгийн зүйлсээр “Өргөсөн тангарагтаа үнэнч” үзэсгэлэн, 2.Монгол улсын төр нийгмийн нэрт зүтгэлтэн АИХ-ын тэргүүлэгч, Сайд нарын зөвлөлийн дарга эрдэмтэн профессор Жамбын Батмөнхийн мэндэлсний 98 насны ойд зориулсан "БИД МАРТААГҮЙ" үзэсгэлэнг тус тус зохион байгуулж нийт 3000 гаруй иргэд үзэж сонирхсон байна. 3.Галсаннамжилын Түмэндэлгэржав (1874-1938)-ын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, “ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаанд	100% 100%

						Музейн сан хөмрөг дэх Түмэндэлгэржав ханы эдлэж хэрэглэж байсан, холбогдолтой эд өлгөөр үзэсгэлэн гаргаж, Эрдэм шинжилгээний ажилтан музейн сан хөмрөгт байх Түмэндэлгэржав ханы холбогдолтой үзмэрийн бүрдэл үнэ цэнэ сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Мөн Увс аймагт Дөрвөд Далай хан Түмэндэлгэржавын мэндэлсний 150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. 4.Эрдэм шинжилгээ хайгуул судалгааны ажлаар Сагил, Давст сумдад ажиллаж Хороон оройн хадны сүг зураг, Ихрийн өвөлжөөний хүн чулуу, Зүүн турагийн хадны сүг зургийг бүртгэн баримтжуулсан.	
2.7	Номын сангийн тухай хуулийн 23.2, 24.4.1, 2020-2024 оны АЗДҮАХ-ийн 2.2.2 Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, номын фондын баяжилтыг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв 12.0	Үйлчлүүлсэн хүний тоо Номын баяжилтын тоо	Үйлчлүүлсэн хүний тоо: 11659 буюу хүн амын 14.7%, ирэгсэд 19794, Номын баяжилт тоо: 1656	Нийт хүн амын 15% буюу 12600 уншигчийг хамруулж, номын фондын баяжилтыг нэмэгдүүлнэ	Нийтийн номын сан 773 /13,272,164 төгрөг/ ном буюу 1%-иар фондоо баяжуулсан. - Төсвөөр 355 /8,609,164 төгрөг/ - Хандиваар 148 /4,663,000 төгрөг/ 19 сумын номын сан 3384 ном буюу 1%-иар фондоо баяжуулсан. - Хандиваар 530 /5,855,000 / - Төсөвөөр 3384 /67,707,200 / Нийтийн номын сангийн байнгын уншигч 9606, ирэгсэд 15950 19 сумын номын сангийн байнгын уншигч 4454, Ирэгсэд 5255 Нийт хүн амын 25%-д хүрч үйлчилсэн.	100% 100%
2.8	Соёлын тухай хуулийн 9.1.4, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын зорилт 1.4, Соёлын сайд, Увс аймгийн	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний	Арга хэмжээ-3 Дэмжлэг үзүүлсэн-	3-аас доошгүй арга хэмжээ зохион	Зохион байгуулж дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ 9 Нийтийн номын сангаас	100% 100%

	Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.5 Түүх, соёл, утга зохиол судлалын орон нутгийн судлаач, зохиолчдыг дэмжих		тоо, дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо	1	байгуулж, дэмжлэг үзүүлсэн байна.	1. Завхан сумын Соёлын төвийн дарга Х.Цэнджавын “НАРАН ЗҮГ НУТАГ” шүлгийн номын нээлт 2. МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Загдын Дамиран агсаны "Тэсийн унаганы янцгаа" номын нээлт 3. Нийтийн номын сангаас Чорос тайж овогт Лодовын Дүгэрсүрэнгийн "Салхин хээтэй ай" шинэ номын нээлт 4. Тод бичгээр бичигдсэн "Цэвэрүүний хангайн шил" номын нээлт 5. Үндэсний бичиг соёл, Номын баяр-2024 арга хэмжээний хүрээнд Нийтийн номын сангаас МЗЭ-ийн Увс салбар "Огторгуйн далай" уран зохиолын нэгдлийн гишүүн яруу найрагчдыг оролцуулан “Зохиолч уншигчдын уулзалт” 6. МУГБ, Хурандаа Манкадайн Мөнхбатын ХАНХӨХИЙН "ГАВЪЯАТ" ХУРАНДАА дурсамж дурдатгал номын танилцуулга /видео/ хийж цахимаар сурталчлах зэрэг ажлыг тус тус зохион байгуулсан. СУАЖЗГ-аас 1. Ховд аймагт 2024 оны 05 сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан “БАРУУН БҮСИЙН СОЁЛ-УТГА ЗОХИОЛЫН ЧУУЛГАН”-д 5 зохиолчийг унааны зардлыг шийдвэрлэж оролцуулсан. 2. Найрагтай өдөр” СУАЖЗГ, Насан туршийн суралцахуйн төв, Нийтийн номын сан, Огторгуйн далай ТББ хамтран 2024 оны 12-р сарын 02-ны өдөр “Найрагтай өдөр” зохиолч уншигчдын уулзалт арга хэмжээний
--	--	--	--	---	-----------------------------------	--

						хүрээнд шүлгийн уралдаан, уран уншлагын уралдаан, сургалт, номын үзэсгэлэн зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж ЕБС-ийн 80 хүүхэд, 7 зохиолчийг хамруулсан. Малчин сумын Соёлын төвөөс 1. МЗЭ- ийн шагналт , МУСТА, зохиолч яруу найрагч Ц, Нүүдэлийн нэрэмжит “ Яруу найраг”-ийн өдөрлөгийг 2024 оны 5-р сарын 22-ны өдөр зохион байгуулсан.	
Зорилт 2. Үндэсний сонгодог, орчин үеийн урлагийн төрлүүдийг хөгжүүлэх бодлогыг тэгш хүртээмжтэй хэрэгжүүлж, үндэсний болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд хүргэнэ.							
2.9	Соёлын тухай хуулийн 21.1.11, Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 6 дугаар, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 3.5 Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд багачуудыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсөв	Оролцогчдын тоо	63 хүүхэд багачууд, уран бүтээлчдийг дэмжсэн	5-аас доошгүй уран бүтээлч, хүүхэд багачуудыг дэмжсэн байна	Нийт 4 тэмцээнд 56 хүүхэд, 45 уран бүтээлчийг дэмжсэн. 1.Улаанбаатар хотод 2024 оны 04 дүгээр сарын 22-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “World Ballet and Dance Grand Prix” олон улсын А зэрэглэлийн Ethnic болон contemporary бүжгийн тэмцээнд Ойрад ХЖТ-ын 5 бүжигчинд Соёл, урлагийн газраас унааны зардал /200 литр бензин/-ын дэмжлэг үзүүлж, Professional couple төрөлд 1 Алтан медаль, 1 Хүрэл медаль” хүртсэн амжилт үзүүлсэн. 2.МУГЖ Б.Дугараагийн нэрэмжит “Алтан өв” бий биелгээний бүсийн наадам Ховд аймагт зохион байгуулагдахад Завхан сумаас 21 хүүхэд оролцож алтан медаль-1, мөнгөн медаль-2, хүрэл медаль-1 хүртсэн амжилт үзүүлсэн. 3. Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан	100% 100%

						Монгол улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д. Лувсаншаравын нэрэмжит 30 дахь удаагийн Найрал дууны улсын уралдаанд Малчин сумын 35 хүүхдийн бүрэлдэхүүнтэй “Хөх яргуй” хамтлаг оролцоход Увс аймгийн ЗДТГ-аас 3.000.000, СУАЖЗГ-аас 750.000 төгрөгийн бензин талоны дэмжлэг үзүүлсэн. 4. 2024 оны 11-р сарын 19-22-ны өдрүүдэд Монголын урлагийн ажилтны холбоо, ССАЖЗЯ-аас зохион байгуулсан Баруун бүсийн театрууд дунд “Дөрвөн цагийн нүүдэл” шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах бүсчилсэн уралдаанд Ойрад ХЖТ уран бүтээлчдийн дэмжлэг үзүүлж оролцуулсан бөгөөд икэлийн чуулга 1-р байр эзэлж, 2-р шатны шалгаруулалтад оролцохоор бэлтгэл ханган ажиллаж байна.	
2.10	Соёлын тухай хуулийн 24.1, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.3, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 3.2 Орон нутгийн угсаатан, ястны соёлын онцлогт суурилсан үндэсний болон сонгодог жүжиг, концерт, дуулалт жүжгийн бүтээлийг шинээр туурвихад дэмжлэг үзүүлэх.	Улс орон нутгийн төсөв	Уран бүтээлийн тоо	Уран бүтээл- 1 Үзэгчдийн тоо-16410	1-ээс доошгүй шинэ уран бүтээл туурвисан байна.	Түүхийн ухааны доктор, дэд профессор На.Сүхбаатарын зохиол “Тэнгэрийн сэнтий” дуулалт бүжгэн жүжгийг туурвиж, Ойрад ХЖТ-т 2 удаагийн тоглолтоор 500 үзэгч, Улаанбаатар хотын Хүүхэд залуучуудын театрт 2 удаа тоглож, нийслэлийн 1500 гаруй үзэгчид тус тус үзэж сонирхсон. Нийт 4 удаагийн тоглолтоор 2000 гаруй үзэгчдэд тоглолтоо сонирхуулсан.	100% 100%

2.11	Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 2.3 Соёлын төвүүдэд түүхэн сэдэвт болон хүүхэд, залуучуудад зориулсан кино гаргаж, кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжих	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо Үзэгчдийн тоо	8 соёлын төвд кино гаргаж байна. Үзэгчдийн тоо 600	2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ. Үзэгчдийн тоог-2100	"Т-интертаймент" студитэй 15 сумын соёлын төв гэрээ байгуулж, кино урлагийг дэмжин түүхэн болон хүүхэд залууст кино урлагаар үйлчлэх боломжийг олгон 36 кино гаргаж 5472 хүн үйлчилсэн байна. Мөн явуулын кино үйл	100% 100%
2.12	Соёлын тухай хуулийн 24.1, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 3.3 Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сан дахь уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэн, сан бүрдүүлж, цахим орчинд түгээх, орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд хүргэхэд дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Үзэгчдийн тоо	Ноот бичвэр-0 Арга хэмжээ-4	Урын сан дахь ноот бичвэрийн 50 хувийг цахим хэлбэрт оруулах, уран бүтээлийг цахимжуулж хүн амын 25-аас доошгүй хувьд хүргэсэн байна.	Театрын урын санд уран бүтээлээ цаг тухайд нь хүлээн авч байгаа ба цахим программыг суулгаж уран бүтээлээ цахимжуулах ажлыг эхлүүлсэн. /Соёлын мэдээллийн GLAM систем хагас жилийн сүүлээр нэвтэрсэн/ Орон нутгийн “МВС телевизтэй 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулж цахим орчинд уран бүтээлээ иргэдэд сурталчлан таниулах ажил хийж байгаа бөгөөд 2024 он эхний хагас жилд “Хөхөө намжил” үндэсний бүжгийн жүжгийг Бүжигчин Г.Батсүх, Б.Бартогтох нар тайзнаа найруулан тавьж орон нутгийн телевиз болон сошиал орчинд сурталчлан таниулж DVD хэлбэрээр Урын сандаа архивлан хадгалж байна.	50%

2.13	Соёлын тухай хуулийн 24.1, Соёлын сайд, Увс аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний нэгдүгээр хавсралтын 3.6 Хүүхдэд зориулсан уран бүтээлийг нэмэгдүүлэхэд орон нутгийн уран бүтээлчдийн шинэ бүтээл, төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, сурталчлах	Улс орон нутгийн төсөв	Уран бүтээлийн тоо	1	2-оос доошгүй шинэ уран бүтээлд дэмжлэг үзүүлж, сурталчилж хамтран ажилласан байна.	Нийт 2 жүжгийг 3200 гаруй хүүхэд үзэж сонирхсон. - Монгол Улсын Хүүхэлдэйн театрийн бүтээл 0.Норолхойгийн найрууллага “Улаан малгайт” жүжгийг Улаангом сумын Соёлын төвийн дотоод нөөц болцоог ашиглан 24 удаагийн тоглолт хийж 2314 хүүхэд хамрууллаа. - Ардын жүжигчин А.Очирбатын зохиол “Баавгай дуулах уу” хүүхдийн дуулалт инээдмийн жүжгийг Ойрад ХЖТ-ын найруулагч СТА Т.Тодхүү шинэчлэн сэргээн найруулж театрын тайзнаа тавилаа. Жүжгээр дамжуулан хүүхэд багачуудад үоо зүй, ёс зүйн боловсрол олгох зорилготой. Уг жүжиг нь нийт 7.0 сая төгрөгийн төсвөөр бүтсэн болно. Жүжгийг 1000 гаруй хүүхэд үзэж сонирхсон.	100% 100%
2.14	Увс аймгийн ИТХ-ын 2021 оны 4/02 тогтоолын хоёрдугаар хавсралтын 11 заалт Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	Улс орон нутгийн төсөв	Тоглолтын тоо Үйлчлүүлэгчийн тоо	Урлагийн тоглолтын тоо-642 Үйлчлүүлэгчийн тоо-143873	Үзвэр, үйлчилгээний тоо, үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлсэн байна.	Ойрад ХЖТ, 19 сумдын соёлын төвөөр 244 тоглолт зохион байгуулагдаж, 22521 хүн хамруулсан. Соёл, урлагийн 22 байгууллагаар: - урлагийн тоглолт 244 - сургалт семинар-200 - дугуйлан 201 - тэмцээн уралдаан 337 - эвент арга хэмжээ 51 - кино үзвэр 120 - Үзэсгэлэн 221 - нийтийн бүжиг 534 зэрэг 1908 соёл олон нийтийн ажил зохион байгуулагдаж, 271506 хүн хамруулсан.	100% 100%

